МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН НЭМЭЛТ ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,148.032... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.06.15. Пүрэв. №116 (4730) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

БАЯН-ӨЛГИЙЧҮҮД Х.БАТТУЛГЫГ ДЭМЖИХЭЭ ИЛЭРХИЙЛЛЭЭ

II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧДИЙН ХОМ-ТЭЙ ТАНИЛЦ

III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +25

Шөнө +12

Дугаарын 60 мөр

## Зөв жишиг

Б.ӨНӨРТОГТОХ

Тээр нэгэн жил АН-ын нэр бүхий улстөрчтэй хамт орон нутагт ажиллах үед Ардын нам ялсан сумын Засаг дарга АН-ын улстөрчөөс зугтаж, сумаасаа яван явтал машинтайгаа айлын хашаанд нуугдаж суусан тухай нутгийнхнаас нь сонсоод ёстой хэлэх үг олдоогүй юм. Хэдийгээр тэд хоёр өөр үзэл бодолтой намын гишүүн ч “Амар байна уу” гэж уулздаг ард түмний минь тэр сайхан ёс жудаг хаачаа вэ хэмээн гайхаж суусанаа нуух юун. Ийм арчаагүй улстөржилт ерөөс амь бөхтэй оршсоор байгаа нь худлаа биш. Дээгүүрээ намчирхаж талцахгүй, төрийн албан хаагч нам бус байна хэмээдэг ч начир дээрээ асуудал шал өөр. АН-ын гишүүн бол ажилд авахгүй, эсвэл АН ялсан үед Ардын намын гишүүд хэн ч биш болдог нь орон нутагт нийтлэг үзэгдэл болсон.

Үргэлжлэл нь III нүүрт

чухал ХҮН

## Ч.НАСАНТОГТОХ: НАЙМАН ОРОЛЦОГЧ НАЙМУУЛАА ДАВТАГДАШГҮЙ ДҮР ТӨРХИЙГ БҮТЭЭЖ ЧАДСАН



Г.ГАНЧИМЭГ

Энэ удаагийн “Чухал хүн” буландаа СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн Орчин үеийн хөгжмийн урлагийн тэнхмийн эрхлэгч, СУИС-ийн хүндэт профессор, МУГЖ Ч.Насантогтохыг урилаа. Домогт “Соёл эрдэнэ” хамтлагийн үнэ цэнэтэй гишүүдийн нэг, орчин цагийн залуу дуучдыг төрүүлэх эрхэм үйлсдээ сэтгэл оюун, эрдэм чадлаа зориулж байгаа билээ. Өнгөрсөн хоёр жилд Монголчуудыг тайзны өмнө уясан “Яг түүн шиг” шоуны арын албанд олон мундаг хүмүүс ажилласан. Тэдний нэг нь яах аргагүй Ч.Насантогтох багш байлаа. Дуучин, жүжигчин нэг бүртээ гадаад дотоодын олон уран бүтээлээр дуулах урлагийн хичээл зааж байсан нь яах аргагүй ямар чадварлаг уран бүтээлч вэ гэдгийг нь харуулсан юм. Тиймдээ ч бид түүнийг урлагийн салбарын “Чухал хүн”-ээр нэрлэсэн хэрэг. Бидний ярилцлага олон сэдвийг хамарсан юм.

Үргэлжлэл нь IV-V нүүрт

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

ОНЦЛОХ МЭДЭЭ

## Хамгийн итгэлтэй дөрвөн сонины нэгээр “Монголын мэдээ”-г нэрлэжээ







Б.СУМЬЯА

ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Удирдлагын академи хамтран Монголд ардчиллыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүр “Ардчиллын бага хурал”-ыг зохион байгуулдаг. Энэ жил уг бага хурлыг чуулган хэлбэрээр өргөжүүлж, “Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн ардчилал дахь үнэ цэнэ” сэдвийн дор Туушин зочид буудлын соёмбо танхимд зохион байгуулсан юм. Чуулганы үеэр Монголдоо хамгийн бодитой судалгаа явуулдаг “Сант марал” сангийн тэргүүн Л.Сумати Монголчуудын хэвлэл мэдээлэлд хандах хандлагын шинэ судалгааны дүнг танилцуулсан нь олны анхаарлыг ихэд татжээ.

Тус сангийн судалгаагаар хамгийн итгэлтэй сонинуудын эхний тавд “Өдрийн сонин”, “Зууны мэдээ”, “Өнөөдөр”, “Монголын мэдээ”, “Ардын эрх” сонин багтсан бол телевизүүдийг Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз, ТВ9, Боловсрол ТВ, Монгол ТВ, Ийгл ТВ тус тус тэргүүлсэн байна.

Сант марал сангийн тэргүүн Л.Сумати судалгааны дүнг танилцуулах явцдаа өдөр тутмын сонинг харьцангуй боловсролтой, хөдөлмөр эрхэлдэг иргэд илүү захиалж, уншдаг талаар дурьдсан юм. Дээрх судалгааг энэ оны гуравдугаар сарын 10-наас гуравдугаар сарын 30-ны хооронд явуулсан бөгөөд Улаанбаатар хот болон Завхан, Хэнтий, Архангай, Төв, Өвөрхангай, Дорноговь аймгуудын нийт 1200 иргэнийг хамруулжээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Н.НОМТОЙБАЯР: Тэтгэвэр нэмэхэд 150 тэрбум төгрөг зарцуулна

Н.БАТЗАЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаяр өчигдөр сэтгүүлчдэд мэдээлэл өглөө. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны харилцан тохиролцсон зарим асуудлын биелэлтийг хангаж ажиллах талаар Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу тэтгэвэр нэмэх шийдвэр гаргасныг танилцуулсан юм. “2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар санхүү эдийн засгийн хувьд хямралтай, маш хүнд нөхцөл байдалтай улс орныг хүлээж аваад ажилласан. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын зүгээс тодорхой шийдвэрүүдийг гаргаж, шаардлагатай арга хэмжээг авсны үр дүнд эерэг үзүүлэлтүүд гарч эхэлсэн. Төсвийн орлого өмнөх дөрвөн жилийнхтэй харьцуулахад нэлээд нэмэгдлээ. Хэдийгээр бид ОУВС-гийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдаж байгаа боловч тооцоолж байсан эдийн засгийн үзүүлэлтүүд маань эерэгээр гарсан.

Үргэлжлэл нь III нүүрт




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2360.00 | 2379.00 | ФУНТ | 2956.00 | 3050.00 |
| ЕВРО | 2614.00 | 2682.00 | РУБЛЬ | 40.70 | 42.70 |
| ИЕН | 21.37 | 21.70 | ЮАНЬ | 347.00 | 351.00 |

| | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2365.00 | 2384.00 | ФУНТ | 2984.00 | 3064.00 |
| ЕВРО | 2624.00 | 2695.00 | РУБЛЬ | 40.46 | 43.56 |
| ИЕН | 21.27 | 21.88 | ЮАНЬ | 347.50 | 351.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# Баян-Өлгийчүүд Х.БАТТУЛГЫГ ДЭМЖИХЭЭ ИЛЭРХИЙЛЛЭЭ

Н.ПУНЦАГ

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгчийг сонгох сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Халтмаагийн Баттулга өчигдөр Баян-Өлгий аймгийн иргэд, сонгогчидтойгоо уулзлаа. Уулзалтын үеэр мэргэжлийн сүмогийн 68 дахь их аварга, Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавьяат тамирчин Асашёорюү Д.Дагвадорж уламжлалаа хүндэтгэн, казах үндэсний малгай өмсөн индэрт гарч ирсэн юм. Тэрбээр "Би Өлгийд ирэх дуртай. Казахстанд явж байхад Өлгийн казах дүү нар маань их таардаг. "Нутгийн ах минь ирлээ" гээд тэвэрч авахад нь өөрийн эрхгүй баярлаж, огшдог. Казахстанд очсон өлгийчүүдийг казах бус монголчууд гэж нэрлэдэг, дууддаг. Гэтэл бид өөрсдөө казахууд гэж ярьдаг. Үүнийг өөрчилмөөр байна. Бид бүгдээрээ нэг монголчууд. Цөөнх нь төрөө дээдэлсэн, төр нь цөөнхөө хүндэлсэн тийм төртэй, Ерөнхийлөгчтэй байхыг хүсч байна. Тэр хүн бол яах аргагүй Халтмаагийн Баттулга билээ. Би та бүхнийхээ шашин, уламжлалыг хүндлээд энэ индэрт тэргүүндээ казах малгай өмсч гарч ирлээ" гэлээ. Мөн казах хэлээр "Сайн байна уу Баян-Өлгий аймгийн ард түмэн. Сайхан зусч байна уу. Ардчилсан намаас нэр дэвшиж буй Халтмаагийн Баттулгыг дэмжиж бүгдээрээ саналаа өгцгөөе. Би казахуудад хайртай. Баттулгын ялалт бүх ард түмний ялалт, казах ард түмний ялалт байх болно. Ховд, Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ, Налайх дүүрэгт байдаг казах үндэстнүүд бүгдээрээ







Баттулгыг дэмжье. Та бүхэнд Рамадан сарын баярын мэнд хүргэе. Өлгийчүүддээ баярлалаа" хэмээн амар мэндийг нь мэдэж, нэр дэвшигч Х.Баттулгыг дэмжихийг уриаллаа. Мөн энэ үеэр Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын малчин Мекен Хумарзах "Би жирийн нэг малчин ард хүн. Энэ индрээс Өлгий нутгийн малчин ардынхаа өмнөөс хэдэн үг хэлье ээ. Би нэг юмыг ер гайхаад олдоггүй юм. Ардчилсан нам эрх барьж байхдаа малчдаа аж ахуй эрхлэгчийн гэрчилгээ, энгэрийн тэмдэгтэй болгож, сайн малчны зээл олгож, ахуй амьдрал, орчин нөхцлийг нь сайжруулахад анхаарч, зээлийн хүүгээ бууруулсан, малын гаралтай түүхий эдийн үнийг тогтворжуулсан гээд маш олон зөв зүйтэй ажил хэрэгжүүлсэн. Дөрөвхөн жилд үнэхээр үр өгөөжтэй ажил хийж хэрэгжүүлснийг мал дагаж яваа малчид андахгүй. Гэтэл нөгөө МАН гэдэг мангас гарч ирээд хийж бүтээсэн болгоныг нь үгүйсгэж, гацааж зогсоох юм. Энэ нам монгол төрийн жолоог 20 гаруй жил атгасан. Энэ урт хугацаанд яагаад юу ч хийгээгүй юм бэ. Тэгсэн хэр нь хийсэн хүмүүсээ үгүйсгэж, гүжирдэж гүтгэх юм. Угтаа бид нэг л нэрэн дор, нэг цэг рүү зорьж яваа ард түмэн биз дээ. Гэтэл ямар санаатай ингэж хөгжил дэвшлийг хойш татаж байдгийг нь ойлгож ухаарахгүй байна. МАН-ынхан малчдын эсрэг хууль журам баталж, дэмжих нь битгий хэл харин ч хөсөр хаядгийг малчин түмэн ойлголоо, харлаа. Одоо малчин түмэн МАН-д санал өгөхгүй ээ. Тэр дундаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Халтмаагийн Баттулгыг дэмжинэ. Эгэл малчин ардаа ойлгодог, ахуй амьдралыг нь мэддэг хүнээ Ерөнхийлөгч болгоно" гэж дэмжихээ

> ...Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулга аймаг бүрт худалдааны төвөөр нь зочилж, худалдаа эрхлэгчидтэй уулзаж байгаа. Гол зорилго нь тухайн аймагт үндэсний үйлдвэрлэл эрхэлж, түүнийгээ иргэдэд борлуулах үйл ажиллагаа газар дээрээ ямар байгаа эсэхийг харах юм...

илэрхийлэв. Үүний дараа нэр дэвшигч Х.Баттулга Өлгий хотын худалдааны төвөөр орж, худалдаа арилжаа хийж буй казах түмэнтэй уулзсан юм. Худалдааны төвтэй танилцах үеэрээ тэрбээр казах түмний үндэсний хөгжим болох домбор худалдан авчээ. Үүгээр зогсохгүй УИХ-ын гишүүн Д.Муратын хамтаар домбор тоглож, сонирхууллаа. Харин худалдагчид "Казах хүн бүрийн тоглож чаддаг домбор хөгжмийг сайн сурах авьяас байгаа"-г хэлж, баяр хүргэж, дэмжихээ илэрхийлсэн юм. Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Х.Баттулга аймаг бүрт худалдааны төвөөр нь зочилж, худалдаа эрхлэгчидтэй уулзаж байгаа. Гол зорилго нь тухайн аймагт үндэсний үйлдвэрлэл эрхэлж, түүнийгээ иргэдэд борлуулах үйл ажиллагаа газар дээрээ ямар байгаа эсэхийг харах юм. Харамсалтай нь, ихэнх аймгийн худалдаа эрхлэгчид урд хөршөөс импортолсон бараа бүтээгдэхүүн зарж байв. Харин Баян-Өлгийн ард түмэн өөрсдийн үйлдвэрлэсэн, үндэсний онцлогийг шингээсэн уран хатгамлын соёлыг хадгалсан бараа бүтээгдэхүүн урлан худалдаж буйд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа.

СОНГУУЛЬ-2017

## С.Ганбаатар: Би олигархи бүлэглэлд барьцаалагдахгүй Ерөнхийлөгч болно

"Өөр гарц байна, бидэнд итгэ" уриатай 2017 оны Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшиж байгаа Сайнхүүгийн Ганбаатар энэ удаа эх орны баруун хязгаар Завхан аймагт ажиллалаа. Завханчууд нэр цэвэр, шударга , эх оронч хүү Сайнхүүгийн Ганбаатарыг дэмжиж, Монголоо аврах их үйлсэд нь хамтран зүтгэнэ гэдгээ илэрхийлж байна.

Уулзалтын эхэнд "Улиастай" захаар орж Завханчуудын санал бодлыг сонслоо. Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд уналтад орсноос болж алс хязгаар нутагт амьдарч байгаа иргэдийн амьжиргаа өдөр ирэх тусам муудаж байгааг хөдөөгийн иргэд учирлалаа. Энэ бол Монголоо гэсэн чин сэтгэлгүй улстөрчдийн бодлогын алдаа. Үүнд МАНАН-гийн олигархи бүлэглэл буруутай. Тиймээс энэ удаагийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Сайнхүүгийн Ганбаатарыг дэмжинэ гэдгээ иргэд ярилаа. МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар түүний багт Монголоо аврах төлөвлөгөө бий. Өнөөдөр Монгол Улсын гадаад өр 25 тэрбум америк долларт хүрч, нэг иргэн 25 сая төгрөгийн өрөнд өөрөө ч мэдэхгүй орчихоод байна. Ард түмнийг өрөнд оруулсан хүмүүс бол төрийн алдаатай бодлого явуулсан МАН-АН-гийн олигархи бүлэглэл. Харин энэ өрнөөс Монгол Улсыг салгаж, монгол хүн эх орондоо сайхан амьдрах боломжийг бий болгох төлөвлөгөө МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатар болон түүний багт байна. Завханчууд сүүлийн хэд хэдэн сонгуулиар МАН-ыг АН-аар, АН-ыг МАН-аар сольж сонголт хийж үзсэн ч өнөөдөр өөрчлөлт гараагүй, харин ч нам дагасан талцал, хуваагдал орон нутагт газар авч , жирийн төрийн албан хаагч эмэгтэй өөрийгөө шатааж амиа хорлоход хүрсэнд иргэд бухимдалтай байна. Тиймээс энэ удаа Монгол Улсад шударга ёсыг тогтоож чадах, улс төрийн олигархи бүлэглэлийн гар хөл болоогүй Сайнхүүгийн Ганбаатарыг дэмжиж, сонголтоо өөрчилнө гэдгээ завханчууд илэрхийллээ.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ-2017

# Архангайчууд улсын баяр наадмыг нээх ерөөл өргөлөө

Арын сайхан хангайн зон олон МАН-аас Ерөнхийлөгчид нэр дэвшигч М.Энхболдыг Дэмид жанжны талбайдаа алгаа дэлгэн угтаж авлаа. Уулзалтыг нээж тус аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат үг хэлж, хүчтэний өлгий нутгийн бэлгэдэл болгон Тайхар чулууг өргөсөн Бөхбилэгтийн баримлыг нэр дэвшигчид дурсгасан юм. Тэрбээр "Арын сайхан хангайчууд Миеэгомбын Энхболд даргыг хоёргүй сэтгэлээр дэмжинэ гэдэгт итгэж байна. Миеэгомбын Энхболд дарга Монгол төрийн төлөө ачааны хүндийг үүрч, хамгийн сүүлд УИХ-ын даргын албыг хашсан арван сар гаруйн хугацаанд хийсэн ажлаас цухасхан дурдъя. Арав гаруй сарын өмнө шинэ Засгийн газар байгуулагдахад "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувийг ард түмнээс нууцаар хувийн компанид өгчихсөн асуудал гарсан. Энэ хувийн компанид өгсөн 49 хувийг төрийн мэдэлд эргүүлэн авчрах үүргийг өгч, төрийн мэдэлд авчрах санааг гаргасан хүн бол УИХ-ын дарга М.Энхболд гэдгийг хэлье. Мөн Монголын төрийн төлөө зүтгэж байгаа хүн ямар нэгэн нууц данстай, мөнгө төгрөг нуусан байж болохгүй гэдэг




санааг гаргасан хүн бол энэ хүн юм шүү. Түүнчлэн М.Энхболд даргын даалгавраар "приус"-ны татварыг Засгийн газар эргэн харж, буцаахаар болсон. Ийнхүү арын сайхан хангайчууд М.Энхболд даргыг алгаа дэлгэн угтаж авч, дэмжинэ гэдэгт итгэлтэй байна" гэсэн юм. Нэр дэвшигч М.Энхболд Архангай нутгийн ард иргэд, залуусыг цаг ямагт дэмжиж ирсэн. "Соёолон" шиг ид гялалзаж яваа гурван залууд итгэл хүлээлгэн УИХ-ын сонгуульд нэр дэвшүүлсний үр дүнд багаараа ялалт байгуулсан, арын хангайн уугуул, УИХ-ын дарга асан С.Төмөр-Очир МАН-ын дэргэдэх Ахмадын холбоог удирдаж яваа, НАМЗХ хэмээх олон мянган залуусын гал голомт болсон их айлыг мөн тус аймгийн уугуул, УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн тэргүүлж байгааг УИХ-ын гишүүн, МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат онцлон дурьдлаа. Мөн УИХ-ын гишүүн, Архангайн уугуул Д.Тэрбишдагва нэр дэвшигч М.Энхболдын удирдлага дор Үндэсний эв нэгдлийн Засгийн газарт гар нийлж ажиллаж байснаа дурссан юм. Эдийн засаг хямралтай байгаа энэ үед УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгч нэг зүгт харж ажиллах учиртай, парламент, засагтайгаа хэл амаа ололцдог, эвийг эрхэмлэдэг төрийн тэргүүнтэй болохын ач холбогдлыг тайлбарлаж, тулхтай, туушстай, туршлагатай, хүний мөс чанартай, ноён нуруутай Миеэгомбын Энхболдыг дэмжихийг уриаллаа. Мөн жүжигчин, Архангайн уугуул Э.Цолмонбаяр эвтэй Монголын төлөө түүнийг дэмжихийг уриалсан юм.

### Б.Батбуян: Улс, үндэстний төрийн тэргүүн гэдэг тулхтай, ноён нуруутай, эв нэгдлийг эрхэмлэгч хүн байх ёстой

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байгаа гурван нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй танилцлаа. Энэ дундаас Монгол Ардын Намаас нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт багш, эмч нарын хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэхээр тусгасан нь сэтгэлд нийцэж байгаа учир Миеэгомбын Энхболдыг дэмжих нь чухал юм. Аливаа улс, үндэстний Төрийн тэргүүн гэдэг, тулхтай, ноён нуруутай, эв нэгдлийг эрхэмлэгч хүн байх ёстой. Миеэгомбын Энхболд энэ шалгуурт тэнцэх, эрдэм мэдлэг, ноён нуруутай хүн гэж үзэж түүнийг дэмжиж байгаа.

### Х.Ганболд: Миеэгомбын Энхболд Монгол Улсад ихийг хийж бүтээсэн, цаашдаа илүү ихийг хийж бүтээх чадвартай хүн

-Миеэгомбын Энхболд Монгол Улсад ихийг хийж бүтээсэн, цаашдаа илүү ихийг хийж бүтээх чадвартай хүн учраас дэмжиж байна. Нам дамжсан, намыг хагалан бутаргасан хүн бол Төрийн тэргүүн байж таарахгүй. Улсын Ерөнхийлөгч гэдэг өрх гэрийн тэргүүнтэй ижил улс орноо хөгжүүлэх өндөр мэдлэгтэй хүн байх шаардлагатай. Харин Миеэгомбын Энхболд цаашид Монгол Улсаа сайн сайхан авч явах, түшигтэй, олон жил улс төрийн албан тушаалд ажилласан туршлагатай учраас дэмжиж, саналаа өгнө.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ҮЗЭЛ БОДОЛ

# ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧДИЙН ХОМ-ТЭЙ ТАНИЛЦ

Б.ТОГТОХ

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасан үндэслэлийн дагуу хуулийн үйлчлэлд хамрагдах албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын цахим мэдээллийн сүлжээнд байршигдах бөгөөд мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т заасны дагуу цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл өгөх журмыг Авлигатай тэмцэх газар батлах хуулийн зохицуулалттай.

Дээрх хуулийг баримтлан тус газрын даргын 2012 оны аравдугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тушаалаар "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэх, мэдээлэл өгөх журам"-ыг баталсан. Иймд дээрх хууль журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус газрын www.iaac.mn цахим хуудсанд байршуулаад байгаа аж. Ингээд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэгтэй танилцана уу.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Нэр дэвшигч Х.Баттулга:**

**Нийт орлого:** 130 сая

**Гэр бүлийн гишүүний орлого:** 31 сая

**Хувьцаа эзэмшдэг компани:** Мах- Импекс ХК, Женко тур бюро ХК, Талх чихэр ХК, Баянгол зочид буудал ХК, Женко тур бюро ХК, Баялгийн хувь ХК, ХИД ХК, Вебсофт ХХК, Ай номадик ХК, Өүпэнспейнс ХХК, Баян-Игрийт ХХК, Их Монгол Чага Интернэшнл ХХК, Наранбаянбүрд Хоршоо, Эрдэнэс Таван толгой ХК, Түмэнхишигтэн ХХК, Монголын Ардчилсан Холбоо, Монголын Жүдо бөхийн Холбоо, Монголын Жүдо бөхийн ордон сан, Их Майдар сан, Ардчилал сонин, Ардчилал сан, Монголын Жүдо бөхийн Академи, Монголын малчдын холбоо, ОУ-ын Жүдо бөхийн холбооны бодлого зохицуулах зөвлөл, Монголын Бодибилдинг, фитнесийн нэгдсэн холбоо гэх мэт нийт 26 компанид тодорхой хэмжээний хувь эзэмшдэг аж.

**Хадгаламжийн бэлэн мөнгө:** Дөрвөн сая

**Мал аж ахуй:** 12 саяын нэг адуу

**Үнэт эдлэл:** 35 сая төгрөгөөр үнэлэгдэх нэг хөөрөг

**Тээврийн хэрэгсэл:** 282 сая төгрөгөөр үнэлэгдэх TOYOTO, LEXUS 570 машин нэг

**Орон сууц барилга байгууламж:** 912 сая төгрөгөөр үнэлэгдэх нэг орон

**Нэр дэвшигч М.Энхболд:**

**Нийт орлого:** 91 сая

**Гэр бүлийн гишүүний орлого:** 118 сая

**Хувьцаа эзэмшдэг компани:** Говь ХК, Зоос гоёл ХК, Авто импекс ХК, Зоос банк ХК, Женко тур бюро ХК, Эрдэнэс Тавантолгой ХК, Технологийн дээд сургууль гээд нийт долоон компаниас хувь эзэмшдэг аж.

**Хадгаламжийн бэлэн мөнгө: 4**83 сая

**Мал аж ахуй:** Хурдан удмын 60 адуу, 300 адуутай. Эдгээр нь 900 саяар үнэлэгдэнэ

**Үнэт эдлэл:** 290 сая төгрөгөөр үнэлэгдэх хоёр эмээл, есөн хөөрөг

**Тээврийн хэрэгсэл:** 120 сая төгрөгийн үнэтэй TOYOTO, LAND GRUISER машин нэг

**Орон сууц барилга байгууламж:** Нэг тэрбум төгрөгөөр үнэлэгдэх хоёр орон сууцтай, нэг хувийн эзэмшлийн байшин.

**Нэр дэвшигч С.Ганбаатар:**

**Нийт орлого:** 22 сая

**Гэр бүлийн гишүүний орлого:** 105 сая

**Хувьцаа эзэмшдэг компани:** Баршим ХХК /25 хувь/

**Хадгаламжийн бэлэн мөнгө:** 36 сая

**Мал аж ахуй:** 60 хонь, хоёр адуу, 47 үхэртэй.

**Үнэт эдлэл:** 17 сая төгрөгөөр үнэлэгдэх нэг хөөрөг, хэт хутга, мөнгөн хазаартай.

**Тээврийн хэрэгсэл:** 9.5 сая төгрөгийн үнэтэй TOYOTO, PRIUS машин.

**Орон сууц барилга байгууламж:** 80 сая төгрөгөөр үнэлэгдэх нэг орон сууц

Дугаарын 60 мөр

## ЗӨВ ЖИШИГ

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэр ч байтугай төрийн өндөр албан тушаалтай хүн ирж байхад манай нам биш хэмээгээд зугтаж оддог гажиг тогтолцоо өнөө хэр ч байсаар байгаа нь Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр тодхон харагдав. Тодруулбал, АН-аас нэр дэвшигч Х.Баттулга Багахангайд ажиллах үед нэг ширхэг ч төрийн албан хаагч уулзалтад очоогүй тухай сошиал ертөнцөөр шуугив. Шалтгаан нь нэр дэвшигчийг уулзалттай өдөр дүүргийн бүх төрийн албан хаагчид гэр бүлийн хамт салхинд гарчихсан байжээ. Гэтэл цаад шалтгаан нь ерөөс зяасаг ноён хүсээгүй учраас тэр юм байх. Энэ мэт асуудал маш олон газарт харагдлаа. Дан ганц АН ч гэхгүй Ардын намын нэр дэвшигчийг яваад очиход Ардчилсан нам ялсан газрын дарга зугтаж байх жишээтэй. Гэтэл энэ удаагийн сонгууль аль нэг намын гишүүн, эсвэл ИТХ-ын төлөөлөгч сонгох асуудал огт биш. Энэ удаагийн сонгууль Монгол Улсын төрийн тэргүүн, бүх ард түмний эв нэгдлийн бэлэг тэмдэг болсон Ерөнхийлөгчийг сонгох төрийн чухал үйл явдал. Нам гэхээс илүү үүнд төр хамаатах учиртай. Хэн байхаас үл хамаарч, төрд тангараг өргөсөн хэн бүхэн төрийн сонгуулиа хүндэтгэн уулзалтад нь очих ёстой юм.

Гэтэл өнгөрсөн хугацаанд өрнөсөн үйл явдлаас харахад төрт ёсны уламжлалаа мэддэг, хүндэлдэг хүмүүс аймаг, сумын Засаг дарга нар дотор цөөхөн байдаг нь илт болов. Ганцхан Увс, Өвөрхангай аймагт л нэр дэвшигч нэг бүрийн уулзалтыг төрийн уулзалт хэмээн хүндэтгэн очиж харагдав. Увс аймгийн Засаг дарга нэр дэвшигч С.Ганбаатар, М.Энхболд нарын уулзалтад суусан бол Өвөрхангай аймгийн ИТХ-ын дарга А.Ишдорж гурван нэр дэвшигчийн уулзалтад бүгдэд нь оролцжээ. Гэтэл үүнийг улстөржүүлж эхэлсэн байх юм. Угтаа энэ залууг төрт ёсны уламжлалаа хүндэтгэснийх нь төлөө, улстөржихгүйгээр төрөө хүндэлсэн, төрийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн сайн түшээ хэмээн магтах учиртай баймаар. Ялангуяа улс төрд хөл тавьж буй залуус түүнээс суралцах учиртай бус уу. Бид нэг л монгол шүү гэдгийг харуулж чадсан А.Ишдоржийн энэ үйлдлийг магтах хүн олон байв. Тухайлбал, УИХ-ын гишүүн асан Ц.Оюунгэрэл өөрийн твиттер хуудсандаа "МАН ялсан газруудад Х.Баттулга нэр дэвшигчээс төрийнхөн бөөнөөрөө зугтаж буй. Өвөрхангай төрт ёсны гүн уламжлалтай болохоор ИТХ-ын дарга нь ирлээ" хэмээн бичжээ. Үнэхээр энэ залуугийн үйлдлээс аймгийн Засаг дарга нар, цаашлаад УИХ-ын гишүүд ч өөрсдөө үлгэр дууриал аваасай. Зөв жишиг.

Монгол төрийн сонгуулийг жалга довны үзлээр харлуулж, юм болгоныг улс төрийн өнцгөөр хардаг муухай монгол зангаа гээхсэн, нөхөд минь. Үр хүүхэддээ бид зөвөөр үлгэрлэхсэн. Монголд одоо 26 улс төрийн хүчин байна. Тэд бүгд өөр өөр үзэл бодолтой хэмээгээд нэгнээ үзэн ядаж, үргэж зугтаад байвал юу болох билээ. Цөөхөн хэдхэн монголчууд маань улс төр гэсэн жижигхэн эрх ашигт хүлэгдэж эртний сайхан уламжлалаа гээж боломгүй баймаар. Монгол төрийн сонгуульдаа хэн бүхэн хүндэтгэлтэй хандаж, төр нам хоёроо ялгахсан, засаг ноёд оо. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчид намын бус төрийн далбаагаа мандуулж өрсөлддөг нь учиртай байж таараа. Нам төрөө ялгах, төрийн тэргүүн намын эрх ашгаас улсынхыг дээгүүр тавина гэсэн санаа биз ээ. АН соргогоороо үүнийг олоод харчихсан байна лээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Н.Номтойбаяр: Тэтгэвэр нэмэхэд 150 тэрбум төгрөг зарцуулна



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Эдийн засаг тэлж, төсвийн орлого нэмэгдэхийн хэрээр хамгийн чухлаар хөндөгддөг асуудал бол тэтгэвэр, тэтгэмж, цалингийн нэмэгдлийн тухай. Өнгөрсөн даваа гарагт Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн улсын хэлэлцээрийн үндэсний хороо хуралдсан. Уг хурлын өмнөхөн Ерөнхий сайдаас чиглэл авч Үндэсний гурван талт зөвшилцөлөөр тохиролцсон хэд хэдэн зүйл заалтын хэрэгжилтийг хангах ажлын хэсгийг байгуулсан. Тухайлбал, 2018 оны нэгдүгээр сарын 1 гэхэд тэтгэврийг нэмэх, ингэхдээ бага тэтгэвэр авдаг иргэдийг өндөр хувиар нэмэх, өндөр тэтгэвэр авч буй иргэдийнхийг харьцангуй бага хувиар нэмэх зарчмаар ажиллах ажлын хэсэг байгуулагдлаа. Ажлын хэсэгт Засгийн газар Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо тус тус ороод ажиллаж байна. Яамны зүгээс 600 мянган айл өрхийн амьжиргааны төвшинг тодорхойлж дууссан. Тэгэхээр бид хэд хэдэн ангиллаар шугам татаж таарна. Үүний дараа судалгааны хэсэг маань хэдэн хувийг бага тэтгэвэр авч байгаа иргэдэд зориулах вэ, өндөр тэтгэвэр авч байгаа хэдэн ахмадад хэдий хэр мөнгө нэмэгдэх вэ гэдэг нь гарах юм. Энэ бүгдийг хийх боломж маань 150 тэрбум төгрөг. Үүнийг шийдвэрлэх процедур маш тодорхой. Улсын төсөв цаг хугацаатай, хуультай. Засгийн газар удахгүй 2018 оны төсвөө хэлэлцэж эхэлнэ. УИХ, Байнгын хороогоороо оруулаад шийдвэр гарна. Харин бид үүнээс өмнө Засгийн газарт тодорхой болгоод оруулах юм. Үүнийгээ бид дангаараа шийдэхгүй. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны санал, байр суурийг харгалзаж шийдвэрлэх зохицуулалттай" гэж танилцуулсан юм.



Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

## ЧУХАЛ ХҮН

# Ч.НАСАНТОГТОХ: НАЙМУУЛА

Төгсгөл.
Түрүүч нь 1 нүүрт

**-Та сайхан зусч байна уу. Таны зуны амралт хараахан эхлээгүй бололтой?**

-Сайхан зусч байна. Бидний амралт хараахан эхлээгүй байгаа. Тэнхмийн эрхлэгч нар долоон сар гаргаж байж л амарч эхэлнэ шүү дээ. Хийсэн ажлын тайлан гаргах, ирэх хичээлийн жилд хийх ажлынхаа төлөвлөгөөг боловсруулах, нийт багш нарынхаа ачааллыг тэгшитгэх, 2017-2018 оны хичээлийн жилд хэчнээн хүүхэд элсүүлэх вэ гээд л бичиг цаасны ажил ид эхэлж байна. Мөн өнөөдөр магистрын диплом гардуулах, маргааш бакалаврын диплом гардуулах ёслол болно. Энэ нь манай сургуулийн хэмжээнд болох өдрийн болон эчнээ ангийн төгсөгчдийн маань эрдмийн баяр, томоохон арга хэмжээ юм.

**-Ер нь их л завгүй байгаа юм байна. Завгүй гэснээс та өнгөрсөн хавар нэлээд ачаалалтай ажилласан байх. Сургуулийн ажлаасаа гадна "Боловсрол суваг" телевизээр гарсан "Яг түүн шиг" шоу нэвтрүүлэгт нэлээд чухал үүрэг гүйцэтгэсэн хүний нэг нь та?**



-Энэ шоуны бэлтгэл ажил, төлөвлөгөө боловсруулах, зохион байгуулалт, маркетинг, менежмэнт гээд дэлгэцийн ард хийсэн ажил зөндөө. Мөн шоуны утга учрыг ард түмэнд ил тод, үнэн зөв, нээлттэй байдлаар үзүүлэхэд маш олон хүчин зүйл нөлөөлж байгаа. Үзэгч нэг кноп дараад л хүссэн нэвтрүүлгээ үзэх амархан. Харин социализмын үеийн суперстаруудыг өнөөгийн нийгэмд орчин цагийн урлагаар дамжуулан шинэ залуу уран бүтээлчид "дахин амилуулж", энэ шоугаар дамжуулан өөрсдийнхөө чадал чансааг амьдарч буй нийгмээрээ тодорхойлуулна гэдэг нэлээд эрсдэл өндөртэй. Гэхдээ манай оролцогчид үүнийг маш сайн чадаж, зам мөрөө улам батжууллаа. Түүнчлэн манай орчин цагийн соёл урлаг гадаадын урлаг соёлтой мөр зэрэгцэх хэмжээнд очиход энэ шоу нэвтрүүлэг маш их түлхэц өгсөн. Үүнд оролцогчид, шүүгчид, арын албаныхан гээд энэ нэвтрүүлгийг бүтээхэд гар бие, сэтгэл оюунаа чилээсэн хүн бүхэн маш их үүрэг гүйцэтгэж байгаа. Гадаадын 36 оронд болж буй шоуг Монголд ч гэсэн яагаад хийж болдоггүй юм бэ гээд л шууд хийчихээгүй. Зөвшөөрөл авах, хөрөнгө санхүү босгох гээд бүх зүйлийг тэгээс эхэлж байж л энэ сайхан нэвтрүүлэг бүтэж боссон. Шоу нэвтрүүлэг хийх нөхцөл бүрдсэнээр бүх зүйл бас "ок" болчихгүй. Ямар баг бүрдүүлэх вэ, ямар маркетинг хийх вэ, яаж зохион байгуулбал үзэгч түмэнд гоёор хүрэх вэ, энэ ажлыг хийхийн тулд энэ багт хэн хэн байх вэ гэдэгт "Боловсрол суваг" телевизийнхэн маш их ач холбогдол өгч ажилласан. Мөн энэ шоуг дэмжиж ажилласан баг бүрэлдэхүүн бүхэнд баярлаж талархаж байна. Тиймээс хамгийн түрүүнд энэ шоуг дэмжиж, Монгол Улсад цоо шинэ шоуг оруулж ирэхэд дэмжиж ажилласан байгууллагуудад хамгийн ихээр талархаж буйгаа "Монголын мэдээ" сониноор дамжуулан дайя.

**-Манайхан янз бүрээр шоу нэвтрүүлэг хийх гэж оролдож байсан. Үнэндээ "Яг түүн шиг" шоу шиг өндөр төвшинд хийсэн нь үгүй. Оролцогчдын чансаа ч их өндөр, дандаа мэргэжлийн хүмүүс л оролцсон юм уу гэмээр байсан. Та орчин үеийн дууны урлагт өөрийн хувь нэмрээ оруулаад, бас араасаа төрж гарах дуучдыг бэлтгээд явж байгаа хүний хувьд залуучуудын дуулах ур чадварыг хэрхэн үнэлж байна вэ?**

-Миний хувьд дуулах ур зүйн багшаар хоёр дахь жилдээ ажилласан. Сэтгэл өндөр байгаа. Манай залуус үнэхээр мундаг байсан. Аль нэгийг нь ялгаж ярих утгагүй. Юуны өмнө "Боловсрол суваг" телевизийнхээ хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлэх ёстой. Хамгийн гол нь энэ шоу дуучин болох хүсэл эрмэлзэлтэй ч дуучин болж чадаагүй, магадгүй дуучин болсон ч мэргэжлээрээ ажиллаагүй, умартаад явж байгаа залуучуудад эргэж нэгийг бодогдуулсан болов уу. Эхний жилийн шоунд дуулаачаас тэс өөр мэргэжлийн хүмүүс оролцсонд баярлаж, өнөөдрийг хүртэл тэднээрээ бахархаж явдаг. Яагаад гэвэл, тэд анхных гэдгээрээ ард түмэнд мартагдашгүй дурсамж, гайхалтай сайхан мэдрэмжийг үлдээж чадсан. Өөрсдөд нь ч гэсэн уран бүтээлийн маш олон дүр зургийг бий болгож, илүү эрч хүчтэй ажиллах энергийг бэлэглэсэн гэж боддог. Тэр шоунд оролцсоноор зарим уран бүтээлчийн нэр хүнд гадаадад өсч, илүү олон уран бүтээл хийх зам мөр нь хүртэл тавигдаад явж байна. Манай Н.Мөнхсоёл Солонгост олон сарын гэрээтэйгээр нэвтрүүлэгт оролцсон. "Яг түүн шиг" шоугаар л Н.Мөнхсоёлыг олоод харчихсан байна шүү дээ. Тиймээс энэ мэтчилэн шоу утга учиртай, үр дүнгээ өгч байгаа. Тэр ч байтугай тэс өөр мэргэжлийн топ моделиудыг энэ шоунд амжилттай оролцуулсан. Бүтэн сарын турш бүжиг, жүжиг, долоо хоногийн дотор дуу бэлдүүлээд, make up зэрэг шоутай холбоотой бүхнийг мэргэжлийн хүн шиг сурна гэдэг амаргүй даваа. Мэргэжлийнуранбүтээлчидтэй тэднийг өрсөлдүүлнэ гэдэг бол том эрсдэл, хэцүү зүйл. Анх нэлээд бодсоны эцэст "Боловсрол суваг" телевизийн урилгыг хүлээн авч, дуучин болоод мэргэжлийн бус ч дуулах дуртай хүүхдүүдээ бэлдэж байлаа. Эргээд үр дүн харагдаж байгаа нь л хамгийн сайхан зүйл. Оролцогчид маань мэргэжлийн дуучин биш ч тухайн үед гурвуулаа л долоо хоногийн ялагчаар шалгарч байлаа. Хэрэв байгалиас заяасан дуу хоолойны өгөгдөл байгаа л бол богино хугацаанд эрчимтэй хичээллэж ажилласнаар өөрсдийгөө шинээр нээж болохыг тэд маань харуулж чадлаа. Энэ жилийн шоунд ч гэсэн манай оролцогчид мөн л ялгаагүй өнгөрсөн жилийн оролцогчид шиг маш их эрч хүч, хурдтай ажилласан. Бүгдээрээ л суурь сайтай, мэдлэг боловсролтой, хэлсэн ярьсан зүйлийг дор дор нь тусгаж авч байсан учраас ажиллахад хялбар байсан.

> ...Хэрэв байгалиас заяасан дуу хоолойны өгөгдөл байгаа л бол богино хугацаанд эрчимтэй хичээллэж ажилласнаар өөрсдийгөө шинээр нээж болохыг тэд маань харуулж чадлаа. Энэ жилийн шоунд ч гэсэн манай оролцогчид мөн л ялгаагүй өнгөрсөн жилийн оролцогчид шиг маш их эрч хүч, хурдтай ажилласан. Бүгдээрээ л суурь сайтай, мэдлэг боловсролтой, хэлсэн ярьсан зүйлийг дор дор нь тусгаж авч байсан учраас ажиллахад хялбар байсан...

**-Гэхдээ дууг зүгээр нэг дуулаад өнгөрөх нэг өөр. Харин байгалиас заяасан өгөгдөл дээрээ зүрх сэтгэлээ зориулж, бүр чин сэтгэлээсээ дуугаа мэдэрч, түүнийг амилуулж дүр бүтээн жүжиглэх бас нэг ондоо шүү дээ?**

-Өөрийнхөө нүүр царайгаар илэрхийлэх, жүжиглэх нэг өөр. Сэтгэлээрээ өөрийгөө хөглөн тэр дууг амилуулж дуулах, дууны дотоод ертөнцийг өөрийн сэтгэлийн дотоод ертөнцтэйгөө холбож үзэгчдэд хүргэнэ гэдэг бол өөрөө асар нарийн ур ухаан. Манай уран бүтээлчид өөрсдийнхөө хэмжээнд, өөрсдийнхөө шавхагдашгүй уран бүтээлч сэтгэлгээгээр өөрийнхөө дотоод сэтгэлийн мөн чанарыг ямар ч байсан үзүүлж чадаж байгаа уран бүтээлчдийг зөв сонголттойгоор энэ шоунд оруулж чаддаг. Өөрөөр хэлбэл, хүссэн болгон нь бас энэ шоунд оролцох боломжгүй. Энэ шоунд оруулахын тулд өнөөгийн энэ нийгэмд хэрхэн яаж залуучуудад сайн үлгэр дууриал болох, сайхан уран бүтээлч хэвээрээ явахын тулд зам мөр нь улам дардан байх, тухайн уран бүтээлчийн дотоод ертөнцийг энэ шоугаар дамжуулж яаж нээж үзүүлэх вэ гэдэг зөв бодол, энерги "Боловсрол суваг" телевизийнхэнд байдаг юм билээ. Түүнийгээ энэхүү шоутайгаа хослуулан залуучуудын нийгэмд эзлэх байр суурь, тухайн хүний шавхагдашгүй нөөцийг ашиглан урлагаар маш олон талаас нь үзүүлдэг. Нэг оролцогч гэхэд л хөгшин, залуу, эсвэл хар арьстан гээд янз бүрийн дүрд хувирч, авьяас чадвараа дайчилсан. Найман оролцогч наймуулаа л давтагдашгүй дүр төрхийг бүтээж чадаж байлаа. Яахав, шүүгчид ажлаа хийж байгаа хүмүүс учраас янз бүрээр хэлэх тохиолдол байсан. Заримдаа шүүгчид оролцогчдоо хараад гайхширч ч байлаа. Хүлээж төсөөлж байснаас нь илүү авьяас чадварыг оролцогчдоосоо бас олж харсан шүү дээ. Нэг хэсэг нийгэм тэр аяараа "Яг түүн шиг" шоугаар амьсгалсан. "Яг түүн шиг" бол XXI зуунд гарч ирж чадсан, хүн болгон үзэх дуртай, залуучуудын маань хийж байгаа шоу. Манай иргэд ч ярьж байна шүү дээ. "Халтар царайт"-ыг үзэж байхад гудамжаар нэг ч хүн явдаггүй байлаа. Энэ шоу яг тэр үеийг эргээд авчрах шиг болсон. Орой 20 цагаас шоугаа үзэхийн тулд гэр орныхоо бүх ажлыг амжуулдаг гэж. Хоолоо хийгээд идчихсэн, хүүхдүүдээ усанд оруулчихсан, ахуй амьдралын аар саар асуудал бүхнийгээ энэ шоунаас өмнө амжиж зохицуулж байлаа шүү дээ.

**-Та залуучуудаа их магтаж байна. Гэхдээ өмнөх үегүйгээр бид бас мундаг болж цойлохгүй л дээ. Та ер нь энэ их ажлыг яаж амжуулдаг юм бэ. Танаас ч гэсэн суралцах зүйл их байгаа нь харагдаж байна. Сургууль, телевизийн хооронд гүйхээс гадна өнгөрсөн хавар "Үерхэл чамайгаа нандигнана" тоглолтоо хийсэн шүү дээ?**

-Би хувьдаа бүхий л зүйлийг амжуулах ёстой гэдэг зарчим баримталдаг. Өөрийгөө голохгүй, харин ч авьяас чадвараа дайчлан өөрийнхөө хэмжээнд хүрч болох бүхий л нөөц боломжоо шавхаж, зорилгодоо хүрэхийн төлөө хичээж ажилладаг, ажилласаар ч байгаа. Би хэдий их ажилтай байлаа ч гэсэн хүн хүнийг хүндлээд, хамтарч ажиллахад үр дүн гарна гэж итгээд, "Ийм уран бүтээлч байвал манай шоунд оролцогчдод цэнэг хайрлана. Бидэнтэй санаа нийлж хамтарч ажиллана байх" гэдэг үзэл бодол, итгэл найдварыг нь үгүйсгэхийг хүсээгүй. Нөгөөтэйгүүр, тэр том шоуны ард гарах гээд бүхэл бүтэн баг нэг хүч болчихоод байхад би хэчнээн их ажилтай байсан ч гэсэн "Үгүй" гэж хэлэх зүрх байгаагүй юм. Миний эрхэлж буй ажил бас л цаг наргүй. Одоо ч гэсэн би нэг хурлад явах гээд л өнгөлзөөд л сууж байна шүү дээ. "Үерхэл чамайгаа нандигнана" тоглолтын тухайд би нэг мэдсэн тайзан дээр 40 жил болчихсон байсан. Дээрээс нь миний дуулдаг "Үерхэл чамайгаа нандигнана" дууг гурван гавьяатын төрүүлсэн уран бүтээл юм билээ. Монгол Улсын гавьяат багш Л.Галмандах хөгжмийг нь зохиож, Монгол Улсын гавьяат багш, яруу найрагч Д.Мандахсан шүлгийг нь бичиж, би дуулсан. Энэ дуу маань эдүгээ 30 дахь жилийн хавартайгаа золгож байна. Үүн дээр нэмээд манай СУИС анх 1997 онд эстрад дууны анги байгуулж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэж эхлээд 20 дахь жилтэйгээ золгож байгаа юм. Олон сайхан түүхт давхцал таарсан учраас би энэ бүхнийг нэгтгээд өнгөрсөн оны сүүлчээр "Орчин үеийн хөгжмийн урлагийн тэнхмийн нээлттэй өдрүүд" гэж долоо хоногийн нээлттэй өдөрлөгийг хоёр дахь удаагаа зохион байгуулсан. Өмнө нь хоёр, гурван жилийн өмнө бас хийж байлаа. Энэхүү өдөрлөгтөө нэртэй уран бүтээлчдийг урьж оролцуулан, хандивын тоглолт хийж, үе үеийн төгсөгч, багш оюутнуудын хамтарсан болон дан багш нарын тоглолт, тэнхмээ сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулсан. Харин хандивын тоглолтдоо зориудаар хөгжлийн бэрхшээлтэйболоодалслагдсан дүүргүүдэд амьдардаг хүүхдүүдийг оролцуулсан даа.

**-Та дуучдаас хамгийн анх Монгол Улсын гавьяат жүжигчин цолыг хүртсэн. Араасаа маш олон гавьяат төрүүлсэн булган сүүлтэй хүн юм билээ?**

-Би эстраддаа хоёр дахь, дуучдаасаа анхны гавьяат нь л даа. Соёлын төв өргөөний захирал Б.Байгалмаа болон "Соёл эрдэнэ" хамтлагийн маань уран бүтээлчид дэмжиж, Монголын ард түмний хайр хүндлэлийг хүлээж 1990-ээд оны сүүлчээр Монгол Улсын гавьяат жүжигчин хэмээх эрхэм цолоор шагнуулж байлаа. Миний өмнөх буюу "Соёл эрдэнэ" хамтлагаас төрсөн анхны гавьяат бол ууган гишүүдийн нэг, хөгжмийн зохиолч, гайхалтай мундаг гитарчин Д.Галсанбат ах маань


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06-р сарын 15-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Хог тээврийн автомашин худалдан авах**
Тендер шалгаруулалтын дугаар: **НДХААА-2017/Б-12**

**Налайх дүүргийн Худалдан авах** ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Хог тээврийн автомашин**–ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000 төгрөг**, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:**
**Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онд 60.0 сая төгрөгөөс багагүй байна.**
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
**60.0 сая төгрөгөөс багагүй**
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
**2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлэх**
Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:
**Сүүлийн 2 жилийн хугацаанд 60.0 сая төгрөгөөс багагүй**
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:
**Шаардлагагүй**

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулах бөгөөд тендерийн хамт 2 000 000 /хоёр сая/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 07–р сарын 17–ны өдрийн 10.00 цагаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07–р сарын 17–ны өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: "Тооцохгүй"**
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: "Тооцохгүй"**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо,**
**Хуульчдын гудамж, Тохижилт үйлчилгээний газрын байр,**
**Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.nalaikh-tender.mn**

## ЧУХАЛ ХҮН

# АА ДАВТАГДАШГҮЙ ДҮР ТӨРХИЙГ БҮТЭЭЖ ЧАДСАН

1990-ээд оны эхээр хүртэж байсан түүхтэй. Саяхан манай хамтлагаас отгон гавьяат төрсөн. 40-өөд жил бөмбөрчин хийсэн Б.Цолмон маань ямар мундаг уран бүтээлч билээ. Ер нь манай “Соёл эрдэнэ” хамгийн олон гавьяатыг төрүүлж, ард түмэндээ хүлээн зөвшөөрөгдсөн хамтлаг.

**-Үзэгч, сонсогчид таны нөр их хөдөлмөр, цаг завгүй ажиллаж байгааг ойлгож мэдэрч байгаа. Гэхдээ бас нэг хүлээлт бий. Хуучны сайхан дуунуудаа дуулсан бие даасан тоглолтоо хэзээ хийх бол гэж чимээ тавьж суугаа даа?**

-Манай сургуулийн тухайд нэг хүүхдэд хоёр багш оногддог онцлогтой. Тиймээс багш шавь хамтраад өнгөрсөн хавар “Үерхэл чамайгаа нандигнана” тоглолтыг Бөхийн өргөөнд хийсэн. Гурван цагийн турш үзэгч, сонсогчидтойгоо сайхан байлаа. Харин бие даасан тоглолтын тухайд ирэх намар буюу урьдчилсан байдлаар арваннэгдүгээр сард хийхээр товлоод байгаа.

**-Та бие даасан тоглолтоо хийхгүй хэр нь үе үе хандивын тоглолт хийдэг. Анх 10-аад жилийн өмнө “Миний охин сайн хүн болоорой” си ди-гээ гаргаж, олсон орлогоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулна гээд “Монгол ньюс” дээр хэвлэлийн хурал хийж байсныг чинь мэдэх юм байна?**

-Би нийгмийн сайн сайхны төлөө ажлуудыг хийдэг. Түүнийгээ тэр болгон нийтэд зарлаад байхыг хүсдэггүй. Тухайн үед би “Миний охин сайн хүн болоорой” си ди-гээ гаргаж байсан. Яг 10 жилийн өмнө юм байна. Тэр үед манай рок попын уран бүтээлчдээс хэн нь ч си ди гаргаагүй байсан. Би хамгийн анх хүүхдэд зориулсан си ди гаргаж байлаа. Дараа нь манай залуу уран бүтээлчид си ди гаргах ажлыг эрчимтэй хийсэн юм. Хүүхдэд зориулсан бүтээлийг би оюутан байхаасаа буюу 1980-аад оноос эхлээд л дуулсан. Социализмын үе байсан учраас дуулсан дуу болгоноо клипжүүлээд мөнгө зараад явж байсан удаагүй. Хүүхдэд зориулсан уран бүтээлд ч гэсэн яг адилхан л зардал мөнгө гарна шүү дээ. Социализмын үед хүүхдэд зориулсан тусгай программаар соёл урлагийнхан үйлчилдэг байсан. Зундаа лагерь, хүүхдийн зуслангаар зориуд явж тоглох, өвөлдөө 10 жилийн сургуулиудаар явж тоглодог байлаа. Одоо ийм тоглолтууд үнэхээр байхгүй болчихсон. Бүр үгүйлэгдэж байгаа. Хүүхэд залуучуудыг



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

одоо юугаар хүмүүжүүлж, яаж өсгөж дэвжээж байгаа юм бэ. Энэ ажил үнэхээр их хоцрогдсон. Тиймээс би дараа жилээс эхлээд хамгийн гол нь хүүхдүүдийнхээ хүмүүжлийг бодож нас сэтгэхүйд нь тохирсон уран бүтээл хийнэ. Яагаад өнөөдөр хүүхдүүд “Хайраа, би чамд хайртай”-гаас өөр дуу дуулахгүй байгаа юм бэ. Хүүхэд бүрийн нас сэтгэхүйд тохирсон уран бүтээлийг яагаад хийхгүй байна вэ. Монголын Хүүхдийн ордны найрал дууны дугуйлангийн хүүхдүүдийг би “Үерхэл чамайгаа нандигнана” тоглолтдоо оролцуулсан. Би зөвхөн өөрийнхөө оюутнуудыг л гэж явцуурдаггүй. Хүүхдүүд яагаад үе үеийн мундаг дуучидтай хамт тоглолтод орж болохгүй гэж. Тэд хамтарч тоглолтод орсноороо нүд нь нээгдэж, маш олон зүйлийг сурч мэднэ. Цаашид сурч боловсрох үйлдээ илүү их эрч хүч авч байгаа юм. Тиймээс бид хаана хаанаа нээлттэй, бие биеэ дэмжээд явах хэрэгтэй гэж боддог. Уран бүтээлчид маань ч гэсэн өнөөдөр зөвхөн хүүхдийн баяраар л нэг тоглолт хийлгүй, зөвхөн өөрийнхөө тоглолт дээр л хүүхдүүдийг авчирч дуулуулалгүй, эсвэл клипэндээ оруулаад өнгөрөх биш хүүхдүүд зориулж буян хийгээсэй л гэж боддог. Эргээд тоглолтдоо оролцсон хүүхдүүдийг тусалж дэмжээсэй.

**-Таныг бүр хилийн чанадад хүртэл хандивын тоглолт хийсэн гэж сонссон юм байна?**

-Би Америкт байгаа монголчууддаа тоглолт хийж чадаагүй л яваа. Харин гурван жилийн өмнө Америкийн монгол сургуульд очиж хандивын тоглолт хийж байсан. Манайхан Америкт маш их тоглолтоор очдог хэр нь хандивын тоглолт хэзээ ч хийдэггүй. Бид бүгдээрээ л гадагшаа явж тоглолтоо хийх дуртай. Мөнгө олдог уу, олдог. Гэхдээ бид тэнд байгаа монголчуудаа эх орон руугаа татахын тулд зүрх сэтгэлтэй байж, тэдэндээ эерэг санаа төрүүлэхийг хичээх хэрэгтэй. Бид бүгдээрээ Монголдоо элэг бүтэн байвал хэчнээн сайхан бэ. Дээрээс нь тэнд төрж өсч байгаа монгол цустай ч эх хэлээ мэдэхгүй харь хэлээр ярьж байгаа хүүхдүүдийг монгол сэтгэлгээ, хөг аялгуугаар жаахан ч гэсэн хөглөхийн тулд л би хандивын тоглолт хийж, уралдаан зарлаж, үзэсгэлэн зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахын тулд Монголдоо үйл ажиллагаа эрхэлж байгаа хүүхдийн гэсэн тодотголтой, тэднээр овоглож буй хувь, хувьсгалын байгууллага, ТББ-ын үүдийг уйгагүй тогшиж явсан шүү. Эцэст нь найзаасаа, сүү шиг сайхан сэтгэлтэй цөөн хэдэн хүнээс л дэмжлэг авч, оролцогчдынхоо шагнал, медалийг эндээ хийлгээд аваад явж байлаа. Америкт амьдарч буй монголчууд маань халуун дулаанаар хүлээж авсан. Ийм арга хэмжээг зөвхөн Америкт биш монголчууд олноороо суурьшиж, хүүхдүүд, гэр бүлтэйгээ амьдарч байгаа Солонгос, Польш, Унгар зэрэг олон улс оронд зохион байгуулж болно. Манай уран бүтээлчид гадаадад тоглолт хийхдээ хүүхдүүдийг нь битгий орхиж, мартаж байгаарай. Ядаж нэг удаа ч болох нь ээ, хүүхдүүдэд зориулаад хандивын тоглолт хийгээч гэж байнга уриалдаг. Эцэг эхчүүд нь ямар их баярлах бол. Харамсалтай нь хүүхдэд зориулсан тоглолт, уран бүтээлийг дэмжих дэмжлэг хомс. Хувь, хувьсгал, олон улсын ч бай хүүхдээрээ овоглодог хэр нь ийм санал санаачлагыг дэмжихдээ хойрго санагдсан.

**-Та энэ ажлыг хийхдээ ганцаардсан байна шүү дээ?**

-Тийм ээ, гэхдээ би тэгэсхийгээдорхихыгхүсээгүй. Өөрийнхөө боломж чадлаар л үргэлжлүүлээд хийсээр байгаа. Анх 10 жилийн өмнө санаачлан хийж байхдаа ч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэднийг асран халамжилж буй ар гэрийнхний хийсэн бүтээлийг худалдан авч бодит дэмжлэг болооч гэж иргэдээсээ хүсч байсан. Өнөөдөр ч гэсэн энэ уриалгаа мартаагүй. Харин тухайн үед хамтарч ажилласан “Салхич шувуу” ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний төвийнхөндоо одоо ч талархаж явдаг.

**-Монгол дэг сургалтаар олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, дэлхийн жишигт нийцсэн боловсон хүчин бэлтгэнэ гэдэг нь танай сургуулийн эрхэм зорилго юм байна. Эцэст нь, тэнхмийн эрхлэгчтэй нь уулзсан юм чинь дуучин болох хүсэл сонирхолтой хүүхэд залуус “Энэ сургуульд яаж элсдэг юм бол оо” гэдгийг асуугаасай гэж хүлээж байгаа болов уу?**

-Манай сургуульд ч, манай орчин үеийн хөгжмийн урлагийн тэнхимд ч гэсэн Армян, Казакстан, ОХУ-д дээд боловсрол эзэмшсэн, магистраас дээш зэрэглэлтэй багш нар ажилладаг. Манай тэнхим гэхэд 15 багштай. Үндсэн болон цагаар багшилдаг. 100 гаруй өдрийн болон эчнээ ангийн бакалавр, магистрын суралцагчидтайгаар сургалт, эрдэм шинжилгээний ажлаа чармайн явуулж байна даа. Дуучин болох хүсэл сонирхолтой хүүхэд тодорхой шалгуурыг давж байж манай сургуульд элсэнэ. ЕБС төгссөн, элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байх ёстойгоос гадна байгалиасаа заясан өгөгдөл маш чухал. Харин Хөгжим бүжгийн коллеж төгссөн хүүхдүүд тэнд үзсэн хичээлүүдээрээ дүйцүүлэлт хийгдээд дэвшин суралцах боломжтой. Одоо үеийн хүүхдүүд ер нь жаахан шантрамтгай болжээ. Аливаа даалгавар биелүүлэхдээ хойргоших, амарчлах, өнгөн талаас нь харах зэрэг байдал давамгай болсон нь анзаарагддаг. Тиймээс манай сургуульд элсэгчид “Би үүнийг л сурахгүй бол энэ сургуулийг төгсч чадахгүй” гэдэг хатуу шаардлагыг өөртөө тавьж, биеэ дайчлах хэрэгтэй. Зарим нь ч үнэхээр мундаг хүүхдүүд орж ирдэг.


# ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Налайх дүүргийн 2 дугаар хорооны 16 дугаар байрны 1 дүгээр орцны тааз болон орцыг засварлах ажил**”–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналын баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 100’000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Үнийн санал нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Төлбөрийг Төрийн сан банк 100200455009 тоот дансанд тушаана.

Үнийн саналыг **2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 14.00 цаг**-аас өмнө доорх хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 14.30 цаг-т** нээнэ.

Дотоодны давуу эрх: **“Тооцохгүй”**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**



# НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААНЫ ЗАР

“Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 240 дугаар тогтоолоор Ландкруйзер-80 маркын автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

**1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга**

| д/д | Автомашины марк | Улсын дугаар | Үйлдвэрлэсэн он/ашиглалтад орсон он | Худалдах доод үнэ | Дэнчингийн хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ландкруйзер-80 / арлын дугаар HDJ81-0065681/ | 72-72 УНН | 1996/2010 | 5,000,000 | 1,250,000 |

**2. Дуудлагын худалдааны ерөнхий мэдээлэл:**

| | |
|---|---|
| Дуудлагын худалдаа болох хугацаа | 2017 оны 07 дугаар сар 05-ны 10:00 цаг |
| Дуудлага худалдаа болох газар | ШШГЕГ-ын харьяа Хорих 439 дугаар ангийн хурлын заал |
| Худалдах доод үнэ | 5,000,000 төгрөг |
| Дэнчингийн хэмжээ | 1,250,000 төгрөг |
| Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл | Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө. |
| Дэнчинг байршуулах данс | Хүлээн авагч байгууллага: Хорих 439 дугаар анги<br>Банкны нэр: Төрийн сан банк<br>Дансны дугаар: 100040012003 |

**3. Дуудлагын худалдаанд хүсэлт ирүүлэх**

Дуудлагын худалдаанд оролцох хүсэлтийг 2017 оны 07 дугаар сар 05-ны 10:00 цаг хүртэл Булган аймаг, Орхон сум 4 дүгээр баг, ШШГЕГ-ын харьяа Хорих 439 дугаар ангийн Ахлах нягтлан бодогчийн өрөөнд бүртгэнэ. Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.

**4. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах**

Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийг үзэж болох бөгөөд холбогдох мэдээллийг 9816-9186, 7678-9698 дугаарын утсаар авч болно.

# МЭДЭЭЛЭЛ

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ:
   - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
   - Тусгай зөвшөөрлийн хуулбар
   - Голлох мэргэжилтэн, инженер, техникийн ажилчдын анкет /CV/
   - Сүүлийн 3-н жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын мэдээлэл, бүтээлийн жагсаалт ирүүлэх
   - Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 оны санхүүгийн тайлангийн хамт ирүүлнэ.

**Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажил Багц-1**

1. Налайхын дулааны цахилгаан станцыг өргөтгөх ажлын зураг төсөв
2. Баянзүрх дүүргийн 8 дугаар хороонд байрлах 248, 260, 262, 262А-р байрнуудын төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холбох зураг төсөв
3. Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны УС-15 орчмын орон сууцны байруудыг хэрэгцээний халуун усаар хангах ажлын зураг төсөв

**Барилга хот байгуулалтын яамны:**

- 1.3.1. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг. эсвэл

**Эрчим хүчний яамны:**

- 03.9.1. 100 МВт хүртэл эрчим хүчний эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажил эсвэл түүнээс дээш заалт

**Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажил Багц-2**

1. Зүүн хойд бүсийн одоо байгаа 6000 м3 усан сан дээр нэмж W=4x6000м3=24000м3-аар өргөтгөн нийт 30000 м3 болгох ажлын зураг төсөв
2. Толгойтын гэр хороололд тохируулах усан сангийн ажлын зураг төсөв W=2x500м3
3. СХД-ийн Ханын материал, Баруун дүүргийн усан сангийн буух ф400мм шугамыг 21-р хорооллын уулзвар хүртэл ф400мм голч шугамаар кольцо болгох
4. Жуковын музей орчмын ф100мм голч бүхий салбар бохир усны шугам шинээр хийх ажлын зураг төсөв
5. Жуковын музейн урдаас Гадаад харилцааны яамны урд уулзвар хүртэл ф200мм голч бүхий шугамыг ф400мм болгож өргөтгөх зураг төсөв
6. Бохир усны 1 дүгээр коллекторыг шинэчлэх зураг төсөв / Офицерийн аюулгүй тойргийн баруун талаас Сүнжингранд хүртэл/
7. Бохир усны 16 дугаар хорооллын салбар шугам өргөтгөх зураг төсөв /16 дугаар хорооллын хойно "Хөргөлт сервис" ХХК-ны баруун талаас Саруул тэнгэр цогцолбор хүртэл/
8. Бохир усны 124 дүгээр цэргийн ангийн салбар шугам өргөтгөх ф200-300мм-ийн зураг төсөв /Хоол хүнсний технологийн урд талаас Туул жинпангийн зүүн хойд тал хүртэл/
9. Налайх салбар бохир усны шугамын өргөтгөлийн зураг төсөв /Налайхын ф500мм-ийн шугамнаас 1 дүгээр насос станц хүртэл/

**Барилга хот байгуулалтын яамны:**

- 1.3.2. Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг эсвэл түүнээс дээш заалт

**Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажил Багц-3**

1. Амгалан дулааны станцын хойд хэсгээс Улиастай гол руу хийх үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төсөл
2. СХД-ийн 12 дугаар хороо, Толгойтын суваг /Үйлдвэрчний эвлэлийн гудамжнаас баруун уулын суваг хүртэл/ зураг төсөв

**Барилга хот байгуулалтын яамны:**

- 1.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл эсвэл түүнээс дээш заалт

**Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажил Багц-4**

1. Моносын уулзвараас Авто худалдааны төвийн зам хүртэл яндантай худаг сувагчлалын байгууламжийн зураг төсөв

**Барилга хот байгуулалтын яамны:**

- 1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл )

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл

**Инженерийн шугам сүлжээний зураг төсөв боловсруулах ажил Багц-5**

1. Баянзүрх дүүргийн 13,14 дүгээр хороо, Орон сууцны 14 дүгээр хороолол орчмын "И" инженерийн шугам сүлжээний зураг төсөв

**Барилга хот байгуулалтын яамны:**

- 1.3.1. Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг. эсвэл түүнээс дээш заалт
- 1.3.2. Усан хангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг эсвэл түүнээс дээш заалт
- 1.3.3. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/ эсвэл түүнээс дээш заалт
- 1.3.5. Усны барилга байгууламжийн зураг төсөл эсвэл түүнээс дээш заалт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

**Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26–ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 15-ний өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **13 дугаар сургуулийн барилга дээвэр, сантехникийн засвар /Баянгол дүүрэг, 13 дугаар хороо/**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0173**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **13 дугаар сургуулийн барилга дээвэр, сантехникийн засвар** / Баянгол дүүрэг, 13 дугаар хороо/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

1. **Борлуулалтын хэмжээ:**
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.**
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
   **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй байх.**
3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 ондуудад доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**
4. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.**
5. Тусгай зөвшөөрөл:
   **Барилга хот байгуулалтын яамны:**
   **2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт**

Тендерийн баталгааны үнийн дүн: "1,700,000" /нэг сая долоон зуун мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа: **2017 оны 09 дүгээр сарын 28-ний** өдрийг дуустал

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 08 цаг 30 минутаас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 09 цаг 00 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810, Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **"Баруун уулын үерийн хамгаалалтын сувгийн засвар шинэчлэлт /Чингэлтэй, Баянгол дүүрэг, 11.0 км/" ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0016**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **"Баруун уулын үерийн хамгаалалтын сувгийн засвар шинэчлэлт** /Чингэлтэй, Баянгол дүүрэг, 11.0 км/ ажил"-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж цахим тендерийн баримт бичиг болон холбогдох материалыг татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө тендерт оролцох хураамж болох **50 000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- **Борлуулалтын хэмжээ:**
  **Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016)-ийн борлуулалтын орлогын дундаж нь 800,000,000 /найман зуун сая/ төгрөгөөс багагүй байна.**
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
  **400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөгөөс багагүй байх**
- Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
  **Сүүлийн 3 жил буюу 2014, 2015, 2016 онуудад доод тал нь нэг удаа 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс багагүй үнийн дүнтэй далан сувгийн ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.**
- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
  **Сүүлийн 3 жил (2014, 2015, 2016 он)**
- Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм
  **Барилга хот байгуулалтын яамны:**
  **2.3.2 Хөрсний ус доошлуулах, шүүрүүлэх, эргийн бэхэлгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил**

Тендерийн хамт 10 000 000 (Арван сая) төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Баталгааны хүчинтэй хугацаа 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17 -ны өдрийн 11 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757806, Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **34 дүгээр сургуулийн барилгын дээвэр, спорт заалны засвар /Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо/**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0172**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос **34 дүгээр сургуулийн барилгын дээвэр, спорт заалны засвар** /Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

1. Борлуулалтын хэмжээ:
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.**
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
   **Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй байх.**
3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 ондуудад доод тал нь нэг удаа тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**
4. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
   **Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын жилийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.**
5. Тусгай зөвшөөрөл: Барилга хот байгуулалтын яамны:
   2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт
   2.2.1 Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт
   2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн баталгааны үнийн дүн: "963,000" /есөн зуун жаран гурван мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ. Тендерийн баталгааны хүчинтэй хугацаа: 2017 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 08 цаг 30 минутаас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 09 цаг 20 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810, Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**

# МЭДЭЭЛЭЛ

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017 оны 06 дугаар сарын 15 өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Налайх дүүргийн автозамын засварын ажил"**
Тендерийн дугаар: **НДХААА-2017/А-08**

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Худалдан авах ажиллагааны алба нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй "Налайх дүүргийн автозамын засварын ажил–ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**
**Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онд 80.0 сая төгрөгөөс багагүй байна.
**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** 80.0 сая төгрөгөөс багагүй
**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2016 оны аудитын тайланг дүгнэлтийн хамт ирүүлнэ
**Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** Сүүлийн 2 жилийн хугацаанд 150.0 сая төгрөгөөс багагүй
**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Шаардлагатай.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулах бөгөөд тендерийн хамт 1 167 000 /нэг сая нэг зуун жаран долоон мянга / төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 07–р сарын 17–ны өдрийн 14.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 07–р сарын 17–ний өдрийн 14 цаг 30 минутанд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: "Тооцохгүй"**
**Дотоодны давуу эрх тооцох эсэх: "Тооцохгүй"**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 2-р хороо,**
**Хуульчдын гудамж, ОНӨААТҮГ байр,**
**Худалдан авах ажиллагааны алба. Утас:7023-2788**
**Цахим хаяг: www.tender.gov.mn, www.nalaikh-tender.mn**

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

**2017 оны 06 дугаар сарын 15-ны өдөр**

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь "Бусад төсөл, арга хэмжээний зураг төсөв боловсруулах ажил"-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна. Тендер нь 3 багцтай.

**Багц №1** Нийслэлийн Онцгой байдлын газрын барилгын зураг төсөв боловсруулах ажил НХААГ 17/0163
**Багц №2** Нийтийн тээврийн техникийн хяналтын үзлэгийн төвийн зураг төсөв НХААГ-17/0164
**Багц №4** "Налайх дүүргийн нутгийн захиргааны ордны барилгын зураг төсөв боловсруулах НХААГ 17/0166

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахи мэдээллийг ирүүлнэ. Үүнд:
- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

**Барилга, хот байгуулалтын яамны**
-1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл
-1.2.4 Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
-1.2.5 Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл /10 кВ хүртэл/
Дотор радио холбоо, галын болон бусад дохиололын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл тусгай зөвшөөрөлтэй байх, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- Татварын Ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт ирүүлэх. Оролцогч нь өөрийн нэвтрэх эрхээ ашиглан системд нэвтэрсэнээр хавсралтаар хүргүүлж буй татварын талаар мэдээллийг гаргаж хэвлэх боломжтой. Хэвлэмэл хуудсыг үнийн саналын баримт бичигт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ;
- Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажуулан ирүүлэх;
- Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл;
- Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл CV-ийг ирүүлнэ.

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
Мэдүүлгийг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 1011 тоот. Утас: 75757810**

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар дараах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

**Энэхүү зөвлөх үйлчилгээ нь:**

Нийслэлийн нийгмийн салбарын барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажил
**Багц 1:** Бага сургууль цэцэрлэгийн цогцолбор барилгын зураг төсөв боловсруулах,
**Багц 2:** Сургуулийн нэг маягын зураг төсөл боловсруулах,
**Багц 3:** 240 хүүхдийн цэцэрлэгийн нэг маягийн зураг төсөл боловсруулах
**Багц 4:** БЗД-ийн 9 дүгээр хороонд баригдах сургуулийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах
**Багц 5:** БЗД-ийн 24 дүгээр хороонд баригдах сургуулийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах
**Багц 6:** БЗД-ийн 13 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 7:** БЗД-ийн 14 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 8:** СХД-ийн 4 дүгээр хороонд баригдах сургуулийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 9:** СХД-ийн 5 дугаар хороонд баригдах сургуулийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 10:** СХД-ийн 27 дугаар хороонд баригдах сургуулийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 11:** СХД-ийн 2 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 12:** СХД-ийн 4 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 13:** СХД-ийн 5 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 14:** СХД-ийн 11 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 15:** СХД-ийн 27 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 16:** СХД-ийн 28 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 17:** СБД-ийн 12 дугаар хороонд баригдах сургуулийн зураг төсөв боловсруулах,
**Багц 18:** СБД-ийн 12 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах,
**Багц 19:** СБД-ийн 15 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 20:** СБД-ийн 16 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 21:** ЧД-ийн 39 дүгээр цэцэрлэгийг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 22:** ЧД-ийн 103 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв боловсруулах
**Багц 23:** БЗД-ийн 88 дугаар сургуулийн спорт заалны зураг төсөв боловсруулах
**Багц 24:** БГД-ийн 13 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 25:** БГД-ийн 114 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөл боловсруулах
**Багц 26:** СХД-ийн 1 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 27:** СХД-ийн 125 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 28:** СХД-ийн 55 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 29:** СХД-ийн 24 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 30:** СХД-ийн 26 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 31:** СХД-ийн 10 дугаар хороонд баригдах цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 32:** ХУД-ийн 53 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 33:** ХУД-ийн 4 дүгээр яслийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 34:** ХУД-ийн 49 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 35:** БЗД-ийн 21 дүгээр сургуулийн барилгыг буулгаж барих зураг төсөв боловсруулах
**Багц 36:** СХД-ийн 107 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгын зураг төсөв боловсруулах ажил
**Багц 37:** СБД-ийн 12 дугаар хороонд баригдах сургуулийн барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 38:** ХУД-ийн 26 дугаар сургуулийн спорт заалны зураг төсөв боловсруулах
**Багц 39:** БГД-ийн 30 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 40:** БГД-ийн 13 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 41:** СХД-ийн Хүнс хангамж төв ОНӨААТҮГ-ын оффисын барилгын зураг төсөв боловсруулах
**Багц 42:** Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын хуучин барилгыг буулгаж, шинээр барих зураг төсөв боловсруулах
**Багц 43:** Эмнэлгийн барилгын их засварын зураг төсөв боловсруулах
**Багц 44:** Нийслэлийн Засаг дарын тамгын газрын дэргэдэх нийгмийн хамгааллын тусгай төвийн барилгын их засварын ажлын зураг төсөл боловсруулах ажил
**Багц 45:** Сургууль цэцэрлэгийн барилгын их засварын зураг төсөв боловсруулах

2. Тус зөвлөх үйлчилгээ нь Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас 2017 онд хийгдэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараахи мэдээллийг ирүүлнэ:
- Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Тусгай зөвшөөрлийн хуулбар

-Барилга хот байгуулалтын яамны: Багц 1-ээс багц 42-д
-1.2.1 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
-1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
-1.2.5.Доторгэрэлтүүлэг,цахилгаанхангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл ) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл тусгай зөвшөөрлийн хуулбар

Багц 43-аас багц -45 д
-1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
-1.2.5.Доторгэрэлтүүлэг,цахилгаанхангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл ) Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл тусгай зөвшөөрлийн хуулбар

- Тус ажлыг хийж гүйцэтгэх инженер техникийн ажилтны дэлгэрэнгүй мэдээлэл, CV
- Сүүлийн 3 жилд /2014, 2015, 2016 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, дэлгэрэнгүй мэдээлэл

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 08:00 цагаас 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл авч болох бөгөөд Цахим Худалдан авах систем (www.tender.gov.mn)-ээр 2017 оны 06 дугаар сарын 26–ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлнэ үү.

**Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, 1011 тоот. Утас: 75757810**

# ЗАВСАРЛАГА

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

## Сайн уу амьдрал минь...



Н.БАТЗАЯА

Хүний амьдралыг номтой зүйрлэвэл ухаарал, инээд хөөр, баяр баяслыг бэлэглэх хуудас нь Их сургуулийн амьдралын он жилүүдийг өгүүлэх тэр нэгэн хэсэг байх биз ээ. Магадгүй хамгийн амттай нь их сургуулийн төгсөлтийн баяр ч байж мэдэх юм. Хүн бүр их сургуулиар өлгийдүүлэн амьдрал гэх их далайд хөл тавьдаг. Хүн бүрийн өмнө эзэмшсэн мэргэжилдээ эзэн нь байж, төгссөн сургуулийнхаа нэрийг өндөрт өргөж явах эрхэм үүрэг оногддог буй за. Энэхүү эрхэм үүрэг нь төгсөлтийн баярын тэр өдрөөс хойш “Сайн уу амьдрал минь” хэмээн урагшлах урам зоригийг нэмдэг. Тэгвэл өчигдөр Монгол Улсын боловсролын салбарт 2840 боловсон хүчин нэмэгдэж, амьдрал гэх их далайд “Сайн уу амьдрал минь...” гэсээр хөл тавилаа. Тодруулбал, Алтан гадас, Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонт МУБИС-ийн төгсөгчдийн “Эрдмийн баяр” болж өндөрлөлөө.

Энэхүү нээлтийн үйл ажиллагаанд тус сургуулийн захирал Д.Мөнхжаргал, БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, хамтран ажилладаг Япон болон Өвөрмонголын сургуулийн зочид төлөөлөгчид оролцлоо. Тус үйл ажиллагааг нээж, МУБИС-ийн захирал Д.Мөнхжаргал “Эрхэм хүндэт эрдэмтэн багш, эцэг эхчүүд, төгсөгчид та бүхэнд “Манлайлагч багш хөгжлийн түлхүүр” уриатай Азийн багш бэлтгэгч их сургуулиудтай өрсөлдөхүйц хэмжээний сургууль болох зорилго өвөрлөсөн Алтан гадас, Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонт МУБИС-ийн 2016-2017 оны хичээлийн жилийн эрдмийн баярт хүрэлцэн ирсэнд талархаж, баяр хүргэе. МУБИС байгуулагдсанаасаа хойш 70 гаруй мянган багш, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэн гаргасан түүхтэй. Тэд маань нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт амжилт гаргаж, Монголын төдийгүй дэлхийн тавцанд нэр алдраа дуурсган бид бүхний бахархал болж байдаг билээ. Манай сургуулийн төгсөгчдөөс Хөдөлмөрийн баатар зургаа, Чингис хааны одонт хоёр, Ардын цолтон 20 гаруй, Академич цолтон найм, Гавьяат цолтон 300 гаруй төрөн гарсныг дурьдахад таатай байна.

Өнөөдөр та бүхэн 2013-2017 оны хичээлийн жилд элсэн суралцаж, өндөр оноотой оюутнууд хэмээгдэж, багш мэргэжлийн тэтгэлэг хүртэн шинэчилсэн хөтөлбөрөөр суралцсан анхны оюутнууд болон төгсөж байна. МУБИС-ийн төгсөгчдийн залгамж халаа болохын зэрэгцээ манай төгсөлтийн түүхэнд бас нэгэн шинэ давалгаа, шинэ түрлэг болон нэмэгдсэнд талархалтай байна” гэв. Тус сургуульд 2013-2014 оны хичээлийн жилд 2986 оюутан элссэн бөгөөд тэдний 823 нь 650-иас дээш оноотой байжээ. Харин өчигдөр тус сургуулийг 2840 оюутан төгслөө. Тэдний дунд 3.7-оос дээш голчтой 200 гаруй оюутан буйг сургуулийн удирдлагууд нээлтийн үеэр онцоллоо. Түүнээс гадна Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонт МУБИС-д гадаадын нийт 267 оюутан суралцдаг гэнэ. Энэ өдөр бакалаврт 46, магистрт 21 нийт 67 гадаад оюутан төгссөн юм. Дөрвөн жил хүсэл мөрөөдөлдөө жигүүрлэн амжилттай суралцсан оюутнууд ажлын байрны урилгатай төгсөж байв. Тус сургуулийн 150 оюутан ажлын байрны урилгатай төгссөн бөгөөд “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд ажил олгогчдын төлөөлөл ч хүрэлцэн ирсэн. Ажил олгогчдын зүгээс “МУБИС-ийн төгсөгчдийг ажилд авахад хэзээд бэлэн байх болно. Учир нь энэ сургууль орчин үетэй хөл нийлүүлсэн чадварлаг, ур чадвартай боловсон хүчинг бэлтгэн гаргаж чаддаг” хэмээсэн. Мөн 3.7-оос дээш голчтой төгссөн оюутанд төрөлх сургуульдаа магистрын ангид 15 хувийн хөнгөлөлттэй суралцах эрхийн бичиг гардуулсан нь баяр дээр баяр нэмсэн үйл явдал боллоо. Энэ үеэр тус сургуулийн төгсөгчидтэй цөөн хором ярилцаж, баярт мөчийг нь хуваалцсанаа хүргэе.



### Г.Цэрэнхүү: Эртний түүхтэй сургуулийн төгсөгч болсондоо баяртай байна



*/МУБИС-ийн төгсөгч/*

-Энэ жил Багшийн сургуулийн 95 жилийн ой тохиож байгаа. Би энэ их агуу түүхтэй сургуульд дөрвөн жил суралцаж, ажлын байртай төгслөө. Маш их баяртай байна. Намайг энэ зэрэгтэй явахад өсгөж хүмүүжүүлсэн аав, ээж, эрдэм мэдлэг хайрласан багш нар болон тусалж дэмжсэн хүмүүстээ маш их баярлалаа. Манай сургуулийг олон алдартай хөгжмийн зохиолч, сайд, эрдэмтэн мэргэд төгссөн. Тэдний үргэлжлэл болж төгссөндөө баяртай байна. Би “Монгол-Оюун” хувийн сургуульд сарын хоёр сая төгрөгийн цалинтай ажилд орж байна. Сургуулийнхаа багш нарт чин сэтгэлээсээ баярлалаа гэж хэлье. Энэ бүхэнд багш нарын минь эрдэм мэдлэг, ур ухааны ач тус их бий.

### О.Болор-Эрдэнэ: Нийт төгсөгчиддөө баяр хүргэе



*/МУБИС-ийн төгсөгч/*

-Юуны өмнө сургуулийнхаа бүх багш нарт маш их баярлалаа гэж хэлэхийг хүсч байна. Мөн бидний баярыг хуваалцахаар ажил олгогчид хүрэлцэн ирсэн. Ирсэн таван сургуулийн удирдлагуудад баярлалаа гэж хэлье. Нийт төгсөгчиддөө баяр хүргэе. Манай сургууль сургалт маш сайтай, багш нар нь хичээл зүтгэл их өндөртэй. Тиймээс ч Монголын үе үеийн шилдэг багш, эрдэмтэн мэргэд энэ сургуулиас төрдөг болов уу гэж боддог. Би “Шинэ Монгол” бүрэн дунд сургуульд ажиллах урилга авлаа.

### Э.Пунцагдаш: Мэргэжил мэдлэгийн хувьд ахиж дэвжсэн



*/МУБИС-ийн төгсөгч/*

-Би 2013 онд МУБИС-ийн Математик, байгалийн ухааны сургуулийн физик электроникийн ангид элсэн орж байлаа. Анх сургуульд орсон үеэ бодоход маш их зүйл өөрчлөгджээ. Хувь хүнийхээ хувьд ч, мэргэжил мэдлэгийнхээ хувьд ч ахиж дэвжсэн зүйл их байна. Дөрвөн жил маш хурдан өнгөрсөн байна. Эрдэмтэн багш нар, аав ээж, ах дүү, үе тэнгийн найз нар маань намайг төгсөхөд маш их тус дэм болсон. Бүгдэд нь баярлалаа.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## “Хүндэт донор”-уудаа АЛДАРШУУЛЛАА







Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Цусны донорын дэлхийн өдөр өчигдөр тохиолоо. Энэ өдрийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв, МУЗН хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 35-аас дээш удаа цусаа бэлэглэсэн ачтан доноруудаа алдаршуулах, иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж, “Бусдын төлөө та юу хийж чадах вэ. Өнөөдрөөс эхлэн тогтмол хугацаанд цусаа бэлэглэцгээе” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Үйл ажиллагааг нээж ЦССҮТ-ийн захирал Н.Эрдэнэбаяр “2016 онд Улаанбаатар хотод 25380, хөдөө орон нутагт 7620 донор буюу улсын хэмжээнд нийт 33 мянга орчим донор цусаа бэлэглэж, 15 нэр төрлийн 82 мянга гаруй нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж эмнэлгүүдийн хэрэгцээг хангаж ажиллаж байна.

Монгол Улс өнгөрсөн онд нийт хүн амын дунд донорын эзлэх хувь 1.1 хувь, нийслэлийн хэмжээнд 1.8 хувьд хүрсэн. Бид энэхүү арга хэмжээг ганцхан өдөр тэмдэглээд өнгөрдөггүй, эл өдрийг угтан олон арга хэмжээ зохион байгуулсан” гэв. Үүний дараа бусдын амь, амьдралыг аврахын төлөө цусаа бэлэглэдэг ачтан доноруудын ариун үйлсийг сурталчлан, олон нийтэд алдаршууллаа. Тухайлбал, 35 болон түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн доноруудад МУЗН-ийн “Хүндэт донор” цол олгосон юм.

Улаанбаатар хотод 2017 онд 52 донор “Хүндэт донор”-ын болзол хангасан байна. Энэ жилийн хамгийн залуу “Хүндэт донор”-оор 21 настай Б.Бямбажав тодорч цол тэмдгээ гардав. Мөн 2001 оноос тогтмол хугацаанд 200 гаруй удаа цусаа бэлэглэсэн 41 настай Д.Бум-Эрдэнийг анх удаа “Топ донор”-оор өргөмжилж, “Топ 200+” цом гардуулсанаараа энэ жилийн үйл ажиллагаа онцлог боллоо. Мөн байгууллага хамт олноороо донорын эгнээнд нэгдсэн МУБИС-ийн Багшийн сургууль, Зэвсэгт хүчний 326 дугаар анги, Улаанбаатар хотын Цагдаагийн газар зэрэг байгууллагыг “Донор хамт олон”-оор өргөмжлөв.







### Бидэнд тохиолдсон хүндхэн хөгтэй явдлууд

**Э. Оюунтуяа**

Вьетнамд үйлдвэрлэсэн цахилгаан жин авлаа. Дээр нь гараад зогсохоор хүний биеийн жинг бүсгүй хүний хоолойгоор хэлдэг гээд л сүрхий сурталчлаад байсан юм. Цахилгаан жингээ авчихаад гэртээ очоод дээр нь гараад зогстол “Накяг дунг ыий” гээд байна аа. Ойролцоо вьетнам засварын монголоор ярьдаг нөхөрт сонсгосон чинь “Нэг нэгээрээ гарч зогсоно уу” гэж байна гэнээ. Хаха

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 24
Шөнө 13

Нөгөөдөр
Өдөр 21
Шөнө 11

## Өдрийн зурхай

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТАХИА ӨДӨР**

**Үс засуулбал:** Өвчин ирнэ
**Наран ургах, шингэх:** 05.00-20.50



*Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, гарагийг тахих, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

СОНИРХУУЛАХАД

## Дэлхийн удирдагчдыг дүрвэгсдийн дүрээр зуржээ



Б.ДАВАА

Сирийн нэгэн зураач дэлхийн бодлогыг тодорхойлох түвшний гэж хэлж болохуйц АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трамп тэргүүтэй дэлхийн 10 гаруй орны удирдагчдийг дүрвэгсдийн дүрээр цувралаар зурж эхэлжээ. Эдүгээ тэдгээр зураг Дубайд олон нийтэд дэлгэгдээд байна. Зураачийг Абдалла Ал Омари гэдэг. Тэрбээр өөрөө иргэний дайн самууны хөлд нэрвэгдсэн Сириэс Европын орныг зорин дүрвэсэн хэдэн мянган иргэдийн нэг бөгөөд өөрийн туршлага, үзсэн харсандаа үндэслэн цуврал зургуудаа бүтээж эхэлжээ. Абдалла ал Омари Бельгид дүрвэгчийн статустайгаар амьдардаг байна. Зураач АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампыг хүүхдээ тэврэн дүрвэж яваа залуухан эрээр төлөөлүүлэн зуржээ. Хүү нь түүний мөрийг дэрлэн унтаж, харин баруун гартаа гэр бүлийнхээ зургийг чанга атгасан байгаагаар дүрсэлсэн байна. Түүнээс гадна ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассадыг ч зуржээ.